



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/316


Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл шинээр олгох,
хүчинтэй хугацааг сунгах, нэмэлт
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, цахилгаан дамжуулах шугам, дэд станц, даралттай зуух, даралтат сав, даралттай дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох хуулийн этгээдийн жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Олгосон тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацааг сунгах хуулийн этгээдийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар, Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл шинээр олгох хуулийн этгээдийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Батзориг)-т үүрэг болгосугай.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

170600000730


Эрчим хүчний сайдын 2025 оны 11 дугаар
сарын 24-ний өдрийн 11/24 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт



Эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, цахилгаан дамжуулах шугам, дэд станц, даралттай зуух, даралтат сав, даралттай дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох хуулийн этгээдийн жагсаалт

Д/д	Компанийн нэр, регистрийн дугаар	Гэрчилгээний дугаар, хугацаа	Код	Үйл ажиллагааны төрөл
1. Цахилгааны чиглэлээр				
1	“Дэлгэрэх төгс хийц” ХХК, 6539378, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг	2748/25 2025-11-24-ний өдрөөс 5 жил	T3-2.2	0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх
2	“Толгойт механик солюшн” ХХК, 7039825, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг	2749/25 2025-11-24-ний өдрөөс 5 жил	T3-2.2	0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх
3	“Мөнх элбэг бүтээл” ХХК, 4098625, Ховд аймаг, Жаргалант сум	2750/25 2025-11-24-ний өдрөөс 5 жил	T3-2.2	0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх


Эрчим хүчний сайдын 2025 оны 11 дугаар
сарын 24-ний өдрийн 22/26 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



**Олгосон тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацааг
сунгах хуулийн этгээдийн жагсаалт**

Д/д	Компанийн нэр, Регистрийн дугаар	Гэрчилгээний дугаар, хугацаа	Код	Үйл ажиллагааны төрөл
1. Дулааны чиглэлээр				
1	“Сонорсүлжээ” ХХК, 5731674, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг	2174/25 2025-11-24-ний өдрөөс 5 жил	ТЗ-2.2	0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх

Эрчим хүчний сайдын 2025 оны 11 дугаар
сарын 24-ний өдрийн 11/24 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт



**Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах
тусгай зөвшөөрөл шинээр олгох хуулийн этгээдийн жагсаалт**

Д/д	Компанийн нэр, Регистрийн дугаар	Гэрчилгээний дугаар, хугацаа	Код	Үйл ажиллагааны төрөл
1	"Тэсбармат" ХХК, 5826713, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг	ЗТ-246/25 2025-11-24-ний өдрөөс 5 жил	ТЗ-8	Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах